



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/89/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь

2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 7052-2734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас:7052-3020

Цахим хаяг:

Аудитор:

Б.Байгал

Утас:99359854

Цахим хаяг: mnbaudit@gmail.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	

1 Аудитын гэрчилгээ


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайвшаанд сум,
Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛААНБАДРАХ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Н.НАМЖИЛСҮРЭН ТАНАА

2019.03.04 № 1-6/254
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Улаанбадрах сумын ЕБС-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт


Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Аудитын гол асуудал:

- Тайлант оны батлагдсан төсвийн хувиарт түлш нүүрс, хоол хүнс, эд хогшил, урсгал засварын зардалд нийт 42908,2 мянган төгрөг батлагдсан. Батлагдсан төсвийг зарцуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийг зөрчин худалдан авах ажиллагааны төлөвлөгөө хийгээгүй, худалдан авах ажил үйлчилгээг нийтэд зарлаагүй, харьцуулалтын арга хэрэглэж гүйцэтгэчийг сонгоогүй, шууд худалдан авалт хийж худалдан авах ажиллагааны тухай хууль зөрчсөн байна.

Дээрх зөрчлүүд нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.4-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно." Засгийн газрын 24 дүгээр тогтоолоор батлагдсан төрийн сангийн үйл ажиллагааны журам 9.1.2. тухайн жилд төсвийн байгууллагын нийлүүлэгчтэй байгуулсан худалдан авах гэрээ захиалгын үнийн нийт дүн нь жилийн батлагдсан төсвийн хүрээнд байна, 9.1.4. энэхүү журмын 9.2 дахь заалтад хамаарахаас бусад тохиолдолд урсгал санхүүжилтийн данснаас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нээлттэй тендер шалгаруулалтын босго үнээс дээш үнийн дүнтэй худалдан авалтын гэрээ байгуулагдсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан энэхүү журмын 4 дүгээр хавсралтад заасан ТТ-4 маягтын хамт Төрийн санд хүргүүлж батлагдсан төсвөөс нөөц үүсгэн бүртгүүлнэ. заасан заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд дээрх алдаа зөрчил нь аудитын гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх тул хязгаарлаж байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 54.3, 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Н.Намжилсүрэн-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019. 02. 27-ноос 2019.02.28–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.03.04-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-ын гэрээт аудитын Мөнгө Нөөц Баялаг Аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2019.02.27-ны өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль нь Эх хэлээрээ цэгцтэй ярьж, алдаагүй цэвэр бичдэг, зөв дадал, хандлагатай иргэнийг төлөвшүүлэх, ёс зүйн дүрмийг сахисан “Чадварлаг баг”-ийг бүрдүүлнэ. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Аймгийн Боловсрол соёлын газар Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Боловсролын нэг буюу хэд хэдэн төвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлэх,

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын

хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

БСШУССайд, Сангийн сайдын 2018 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн А/024/11 дугаар хамтарсан тушаалын хавсралт

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд тодорхойгүй байна.

Бодлогын баримт бичиг аудитад ирүүлсэнгүй

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ACOLOUS” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын

гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 0 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардал*-ын 1 хувиар сонгов.

Нийт зардал-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Аудитын зардлын ажил гүйлгээнд эрсдэл тооцсон болохоор нийт зардалыг суурь үзүүлэлт болгон сонголоо. -холбоотой юм.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны *Нийт зардал* 7,056.76 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 7,056.76 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь 1 холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 0 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	16,201.10	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	1	42,908.20	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	4	59,109.30	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Тайлант оны батлагдсан төсвийн хувиарт түлш нүүрс, хоол хүнс, эд хогшил, урсгал засварын зардалд нийт 42908,2 мянган төгрөг батлагдсан. Батлагдсан төсвийг зарцуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийг зөрчин худалдан авах ажиллагааны төлөвлөгөө хийгээгүй, худалдан авах ажил үйлчилгээг нийтэд зарлаагүй, харьцуулалтын арга хэрэглэж гүйцэтгэгчийг сонгоогүй, шууд худалдан авалт хийж худалдан авах ажиллагааны тухай хууль зөрчсөн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.4.-т "тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно." засгийн газрын 24 дүгээр тогтоолоор батлагдсан төрийн сангийн үйл ажиллагааны журам 9.1.2. тухайн жилд төсвийн байгууллагын нийлүүлэгчтэй байгуулсан худалдан авах гэрээ захиалгын үнийн нийт дүн нь жилийн батлагдсан төсвийн хүрээнд байна, 9.1.4. энэхүү журмын 9.2 дахь заалтад хамаарахаас бусад тохиолдолд урсгал санхүүжилтийн данснаас төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нээлттэй тендер шалгаруулалтын босго үнээс дээш үнийн дүнтэй худалдан авалтын гэрээ байгуулагдсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан энэхүү журмын 4 дүгээр хавсралтад заасан тт-4 маягтын хамт төрийн санд хүргүүлж батлагдсан төсвөөс нөөц үүсгэн бүртгүүлнэ. гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Зардлын ангилал, зардлын тайлагнал бодитоор тайлагнасан эсэх

Анхаарал татахуйц чухал асуудал ажиглагдсангүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 11 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 355,557.7 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 347562,1 мянган төгрөг буюу 98 хувьтай байгаа нь Улаанбадрах сумын ИТХ-ийн 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/42 тоот тогтоолоор Сумын 2018 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулсан. Он дуусах гэж байхад хөрөнгө шийдсэн тул ажил гүйцэтгэх хугацаа байхгүй байсанаас шалтгаалан 7,9 сая төгрөг хэмнэгдэж татан төвлөрүүлсэнээс шалтгаалжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Ерөнхий боловсролын сургууль нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Удирдлагын дээд болон дотоод хяналт

Илрүүлэлт

Төсвийн хөрөнгөөр худалдан авалт хийхдээ зарим ажил гүйлгээний анхан шатны баримтад худалдан авалтыг баталгаажуулсан И баримт хавсаргаагүй байна. Мөн Төсвийн зарцуулалтыг шилжүүлэхдээ зарим ажил гүйлгээнд Засгийн газрын 24 дүгээр тогтоолоор баталсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.8-д заасан нотлох баримтыг бүрдүүлээгүй байна. Энэ нь НББ тухай хуулийн 13 дүгээр зүйл, Засгийн газрын 24 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2017.12.05 ны 347 тоот тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн ААН байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврыг /НХМ-ТМ-5/ тус тус зөрчсөн байна.

Зөвлөмж

И баримтыг худалдан авалт хийсэн ажил гүйлгээ бүрд анхан шатны нотлох баримтаар авч зарцуулалт бүрийн нотлох баримтын бүрдүүлэлтийг сайжруулах.

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Улаан бадрах сумын Ерөнхий боловсролын сургуулийн ийн Захирал Н.Намжилсүрэн нягтлан бодогч Б.Уранбилэг

Эрсдэл

1. Бүртгэлээр тавих хяналт алдагдана.
2. Татварын орлого бүрдүүлэлт, тайлагнал дутуу илэрхийлэх боломж бүрдэнэ.

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дүгээр сарын 28-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

3.2 Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт

Илрүүлэлт

2018 оны санхүүгийн тайланг төсвийн хуульд заасан цаглабрын дагуу аудитын байгууллагат ирүүлээгүй, аудит хийхэд цаг хугацааны хязгаарлалтад орууллаа. Санхүүгийн тайланг 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн дуусгаж ирүүлсэн нь Төсвийн хууль зөрчсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8.9.1-т “Төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” заасан заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Эрсдэл

1. Мэдээ тайлан хугацаандаа хийгдээгүйгээс нэгдсэн мэдээлэл хугацаа хоцрох

Зөвлөмж

Жилийн болон хагас жилийн санхүүгийн тайлан мэдээг хууль журмын хугацаанд үнэн зөв гүйцэтгэж байх талаар удирдлага, санхүүгийн ажилтангаа хянаж ажиллах

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Улаан бадрах сумын Ерөнхий боловсролын сургуулийн ийн Захирал Н.Намжилсүрэн нягтлан бодогч Б.Уранбилэг

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дүгээр сарын 28-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

3.3 Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт

Илрүүлэлт

Тайлант онд үндсэн хөрөнгө 16201,1 мянган төгрөгөөр нэмэгдсэн, Оны эцэст хөрөнгийн тооллого хийгээгүй байна, Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн хөрөнгө худалдан авсан зардлыг тусгаагүй, зардлыг бодит гүйцэтгэлээр нь бус төсвийн хуваарийн дагуу бичилт хийж тодруулга тайланг зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 22.6.7-д “Төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар бүртгэж, тайлагнах”, НББ-ийн тухай хуулийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”заасан заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Эрсдэл

1. Мэдээ тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй

Зөвлөмж

НББББ бичигт заасны дагуу үндсэн хөрөнгө бараа материалын тооллого хийж тооцоо бодож байх, зардлыг бодит гүйцэтгэлээр тайлагнаж байх

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Улаан бадрах сумын Ерөнхий боловсролын сургуулийн ийн Захирал Н.Намжилсүрэн нягтлан бодогч Б.Уранбилэг

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дүгээр сарын 28-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 12 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА

Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ц.ЛҮНДЭГМАА

Огноо:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Б.БАЙГАЛ

Огноо2019.02.28

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>67,594,345.44</u>	<u>65,865,751.35</u>
33	АВЛАГА	1,208,850.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	983,400.00	00.00
335	Бусад авлага	225,450.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	225,450.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	66,385,495.44	65,865,751.35
351	Түүхий эд материал	9,270,796.66	9,244,606.66
35110	Тусгай зориулалттай материал	8,988,766.66	9,047,766.66
35130	Эм боох материал	282,030.00	196,840.00
354	Хангамжийн материал	57,114,698.78	56,621,144.69
35410	Бичиг хэргийн материал	1,641,490.00	1,490,974.00
35420	Аж ахуйн материал	3,646,384.50	7,805,417.50
35440	Түлш, шатах тослох материал	3,579,500.00	742,340.00
35450	Барилгын засварын материал	54,400.00	00.00
35460	Хүнсний материал	2,440,250.00	3,367,254.50
35470	Бусад хангамжийн материал	45,752,674.28	43,215,158.69
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>994,023,284.57</u>	<u>1,030,205,638.36</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	994,023,284.57	1,030,205,638.36
392	Биет хөрөнгө	994,023,284.57	1,029,293,638.36
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,229,788,603.00	915,213,500.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-365,372,637.93	-45,000.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,500,000.00	21,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-18,215,277.71	-20,006,944.37
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	141,038,442.83	129,249,889.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	-74,270,595.12	-70,039,219.73
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	95,938,148.30	95,325,642.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	-61,494,230.32	-64,849,868.43
39214	Бусад үндсэн хөрөнгө	23,573,512.00	23,573,512.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,302,286.48	-7,657,929.32
39217	Нөм	6,839,606.00	7,030,056.00
393	Биет бус хөрөнгө	00.00	912,000.00

Улаанбадрах сумын ЕБС-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	912,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,061,617,630.01</u>	<u>1,096,071,389.71</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,145,000.00</u>	<u>562,731.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,145,000.00	562,731.00
413	Өглөг	2,145,000.00	562,731.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,145,000.00	314,516.00
4136	Бусад өглөг	00.00	248,215.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	248,215.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,059,395,086.88</u>	<u>1,095,431,115.58</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,059,395,086.88	1,095,431,115.58
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	925,674,877.86	926,586,877.86
51101	Өмч: - төрийн	925,674,877.86	926,586,877.86
512	Хуримтлагдсан үр дүн	-80,709,463.45	-419,583,733.15
51210	Өмнөх үеийн үр дүн	-80,709,463.45	-79,955,146.80
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-339,628,586.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	214,429,672.47	588,427,970.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,061,540,086.88</u>	<u>1,095,993,846.58</u>

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	253,512,949.00	366,047,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,918,449.00	9,502,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	21,918,449.00	9,502,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,918,449.00	9,502,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	818,500.00	2,786,900.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	21,099,949.00	6,715,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,020,000.00	987,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	230,574,500.00	355,557,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,020,000.00	987,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	800,000.00	987,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	220,000.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	213,542,521.43	410,580,913.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	213,542,521.43	410,580,913.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	205,712,521.43	393,743,100.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	139,787,697.00	247,804,256.00
210101	Үндсэн цалин	104,319,497.00	188,874,579.00
210102	Нэмэгдэл	17,875,558.00	31,721,755.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	3,294,000.00
210104	Урамшуулал	4,515,147.00	15,133,725.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,077,495.00	8,780,197.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,355,558.00	29,739,971.00
210201	Тэтгэврийн даатгал	9,918,269.00	20,014,430.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,090,097.00	2,462,012.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,276,080.00	1,681,693.00
210204	Ажилгүйдлийн даатгал	279,190.00	735,549.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,791,922.00	4,846,287.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,183,147.00	21,795,212.00
210301	Гэрэл, цахилгаан	3,200,647.00	5,502,552.00
210302	Түлш, халаалт	7,472,500.00	15,025,060.00
210303	Цэвэр, бохир ус	510,000.00	1,267,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,864,438.00	8,084,340.59
210401	Бичиг хэрэг	401,780.00	1,103,950.00
210402	Тээвэр, шатахуун	800,310.00	1,846,980.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,620.00	356,588.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	130,000.00	320,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	461,728.00	979,745.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	3,477,077.59
2105	Нормативт зардал	10,507,668.00	21,332,855.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	74,200.00	177,840.00
210502	Хоол, хүнс	10,433,468.00	21,031,065.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	123,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	836,150.00	1,038,930.00
210604	Урсгал засвар	836,150.00	1,038,930.00
2107	Томилолт, зочны зардал	142,000.00	729,600.00
210702	Дотоод албан томилолт	142,000.00	729,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	332,510.00	526,710.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	332,510.00	526,710.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,703,353.43	62,691,225.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,000.00	712,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,130,505.00	681,825.00

Улаанбадрах сумын ЕБС-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,532,848.43	61,296,700.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,830,000.00	16,837,813.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,830,000.00	8,842,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,483,400.00	8,842,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,346,600.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	7,995,613.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	7,995,613.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>39,970,427.57</u>	<u>-44,533,813.34</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	295,094,773.01
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	251,692.37
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	294,843,080.64
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>39,970,427.57</u>	<u>339,628,586.35</u>

Улаанбадрах сумын ЕБС-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	232,413,000.00	359,331,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	818,500.00	2,786,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	818,500.00	2,786,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	818,500.00	2,786,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	818,500.00	2,786,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	231,594,500.00	356,544,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	230,574,500.00	355,557,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,020,000.00	987,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	800,000.00	987,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	220,000.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	174,528,324.00	359,331,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	174,528,324.00	359,331,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	166,698,324.00	340,911,187.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	139,787,697.00	246,770,099.00
210101	Үндсэн цалин	104,319,497.00	157,009,047.00
210102	Нэмэгдэл	17,875,558.00	41,966,052.00
210104	Урамшуулал	4,515,147.00	21,669,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,077,495.00	26,126,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,355,558.00	31,621,211.00
210201	Тэтгэврийн даатгал	9,771,717.00	18,437,433.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,236,649.00	5,318,769.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,276,080.00	2,110,726.00
210204	Ажилгүйдлийн даатгал	279,190.00	523,115.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,791,922.00	5,231,168.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,710,647.00	18,452,152.00
210301	Гэрэл, цахилгаан	3,200,647.00	5,502,552.00
210302	Түлш, халаалт	00.00	11,682,000.00
210303	Цэвэр, бохир ус	510,000.00	1,267,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,150,910.00	4,163,846.00
210401	Бичиг хэрэг	25,580.00	276,868.00
210402	Тээвэр, шатахуун	800,310.00	2,127,430.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	82,720.00	358,688.00
210404	Ном, хэвлэл	00.00	98,450.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	130,000.00	320,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	112,300.00	982,410.00
2105	Нормативт зардал	5,471,502.00	22,005,772.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	113,600.00
210502	Хоол, хүнс	5,471,502.00	20,067,172.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,825,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	10,781,862.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	7,499,162.00
210604	Урсгал засвар	500,000.00	3,282,700.00
2107	Томилолт, зочны зардал	142,000.00	729,600.00
210702	Дотоод албан томилолт	142,000.00	729,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	332,510.00	532,710.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	332,510.00	532,710.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	247,500.00	5,853,935.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,000.00	1,554,935.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	207,500.00	4,299,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,830,000.00	18,420,613.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,830,000.00	10,425,000.00

Улаанбадрах сумын ЕБС-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,483,400.00	10,425,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,346,600.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	7,995,613.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	7,995,613.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>57,884,676.00</u>	<u>00.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>800,000.00</u>	<u>00.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>800,000.00</u>	<u>00.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	800,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	800,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-800,000.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	57,084,676.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	57,084,676.00	00.00

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Улаанбадрах сумын ЕБС-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	925,674,877.86	215,459,532.00	-91,214,894.46	1,049,919,515.40
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	925,674,877.86	215,459,532.00	-91,214,894.46	1,049,919,515.40
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	19,919,959.78	19,919,959.78
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	925,674,877.86	214,429,672.47	-80,709,463.45	1,059,395,086.88
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	925,674,877.86	214,429,672.47	-80,709,463.45	1,059,395,086.88
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	754,316.65	754,316.65
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	925,674,877.86	214,429,672.47	-79,955,146.80	1,060,149,403.53
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	373,998,298.40	00.00	373,998,298.40
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	912,000.00	00.00	-339,628,586.35	-338,716,586.35
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	926,586,877.86	588,427,970.88	-419,583,733.15	1,095,431,115.58

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Улаанбадрах сумын ЕБС-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	355,557,700.00	347,562,087.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	355,557,700.00	347,562,087.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	344,407,800.00	337,137,087.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	246,771,000.00	246,770,099.00
210101	Үндсэн цалин	156,074,000.00	157,009,047.00
210102	Нэмэгдэл	42,666,000.00	41,966,052.00
210104	Урамшуулал	21,905,000.00	21,669,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	26,126,000.00	26,126,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,624,500.00	31,621,211.00
210201	Тэтгэврийн даатгал	24,416,367.00	18,437,433.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,052,033.00	5,318,769.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,441,667.00	2,110,726.00
210204	Ажилгүйдлийн даатгал	610,466.00	523,115.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,103,967.00	5,231,168.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,464,200.00	18,452,152.00
210301	Гэрэл, цахилгаан	5,504,600.00	5,502,552.00
210302	Түлш, халаалт	11,692,000.00	11,682,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,267,600.00	1,267,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,551,300.00	3,346,646.00
210401	Бичиг хэрэг	300,000.00	276,868.00
210402	Тээвэр, шатахуун	1,600,000.00	1,698,430.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	220,000.00	358,688.00
210404	Ном, хэвлэл	348,000.00	98,450.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	355,200.00	320,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	728,100.00	594,210.00
2105	Нормативт зардал	22,219,700.00	21,465,772.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	280,800.00	113,600.00
210502	Хоол, хүнс	20,068,900.00	20,067,172.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,870,000.00	1,285,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,147,300.00	10,054,862.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,590,000.00	7,499,162.00
210604	Урсгал засвар	2,557,300.00	2,555,700.00
2107	Томилолт, зочны зардал	869,800.00	729,600.00
210702	Дотоод албан томилолт	869,800.00	729,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	560,000.00	532,710.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	560,000.00	532,710.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4200000.00	4164035.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,400,000.00	1,384,935.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,800,000.00	2,779,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11149900.00	10425000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,149,900.00	10,425,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,149,900.00	10,425,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	355,557,700.00	355,557,700.00

Улаанбадрах сумын ЕБС-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	355,557,700.00	355,557,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	355,557,700.00	355,557,700.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	33.00	33.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	15.00	17.00
620003	Үйлчлэх ажилтан	17.00	15.00